



М

ОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

ТУСГАЙ ДУГААР 2019 • IV • № 30

МОНГОЛБАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2016 ОНЫ 7 ДУГААР САРААС
2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САР)



МОНГОЛБАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2016 ОНЫ 7 ДУГААР САРААС 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САР)

Эрхэм уншигч танаа. Энэхүү тусгай дугаараар Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын үр нөлөө, эдийн засагт гарсан өөрчлөлтийн талаар танилцуулж байна.

Монголбанк сүүлийн 2 жил 9 сарын хугацаанд улс орны эдийн засгийг сэргээх, улсын өрийн дефолтын эрсдэлээс зайлсхийх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг сэргээх, банк санхүүгийн салбарыг эрүүл, чийрэг болгоход чиглэсэн бодлого, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж, үр дүнд хүрч ирлээ.

Эдийн засгийн нөхцөл байдал 2016 оны 3 дугаар улиралд нэлээд хүнд байв. Тухайлбал, 2016 оны эхний 3 улиралд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) өмнөх оны мөн үеэс -1.6 хувийн уналттай, -0.6 хувийн дефляцитай, ажилгүйдлийн түвшин 11.6 хувьд хүрсэн, улсын төсөв өндөр алдагдалтай (1.7 их наяд төгрөг), зээлийн өсөлт зогсонги байдалд орсон, банкны салбарын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 15.4 хувьд хүрсэн, зээлийн хүү 20.6 хувьд хүрч өсөн, гадаад валютын цэвэр нөөц Монголбанкны тодорхойлолтоор -402.5 сая ам.доллар, ОУВС-ийн тодорхойлолтоор -2.75 тэрбум ам.долларт хүрээд байв. Энэ хүнд нөхцөл байдалд орох үе 2015 оноос эхлэн хойш үргэлжилсээр, банк санхүүгийн байгууллагуудын алдагдал нэмэгдэж, өөрийн хөрөнгө буураад байсан буюу эдийн засгийн хүндрэл нь санхүүгийн салбарт шилжээд байв.

2016 оны 7 дугаар сард гадаад валютын албан нөөц 1.2 тэрбум ам.доллар, Хятадын Ардын банк (ХАБ)-тай байгуулсан төгрөг, юаны своп хэлцлийн хүрээнд Монголбанк авч ашигласан дүн 1.6 тэрбум ам.доллар, харин дотоодын банкуудтай хийсэн своп хэлцлийн цэвэр дүн 1.4 тэрбум ам.доллар байж, гадаад валютын цэвэр нөөц -2.75 тэрбум ам.долларт хүрсэн байв. Гадаад валютын нөөц ийнхүү буурч,

цэвэр дүнгээр сөрөг буюу өндөр түвшинд хүрсэн, 2016 оны 6 дугаар сард их хэмжээ (400 орчим сая ам.доллар)-ний гадаад валют дотоод зах зээлээс гарсан, төсвийн болон төлбөрийн тэнцлийн олон жилийн алдагдал гүнзгийрсэн, нөгөө талдаа өндөр дүнтэй гадаад өр төлбөрүүд (Хөгжлийн банкны 580 сая ам.доллар, ХАБ-тай байгуулсан хэлцлээр авч ашигласан 12 тэрбум юань, Чингис бондын 500 сая ам.доллар, Димсам бондын 1 тэрбум юань) хүлээгдэж байсан нь валютын захад оролцогчдын хүлээлтэд нөлөөлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2016 оны сүүлийн 4 сард сулрахад нөлөөлөв. Гадаад валютын нөөц ийнхүү бага түвшинд хүрч, макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд бүгд эдийн засгийн хүндрэлийн нөхцөл байдлыг илтгэж байсан тул Монгол Улсын зээлжих зэрэглэл 2016 оны 7 дугаар сараас мөн оны 11 дүгээр сарын хооронд маш хурдацтай буурсан. Тухайлбал, Moody's агентлаг зээлжих зэрэглэлийг 2 шатлалаар бууруулж Caa1 ангилалд оруулсан билээ. Ийнхүү зээлжих зэрэглэл буурснаар Улсын эрсдэлийг өсгөж, гадаад зах зээл дээр гаргасан бондуудын үнэ хурдтай унаж, хүү (Хөгжлийн банкны бондын үнэ унаж, хоёрдагч зах зээл дээрх хүү нь 38 хувьд хүрсэн) нь өсч байв.


Эдийн засгийн эмзэг байдлын холбогдох шинжилгээнүүдээр шуурхай арга хэмжээ авахгүй бол нөхцөл байдал улам хүндрэх, энэ хүндрэлийг дан ганц дотоод нөөц бололцоогоор даван туулах боломжгүй гэсэн дүгнэлт гарч байв. Учир нь Засгийн газрын өр өндөр түвшинд хүрч, хуулиар тогтоосон тусгай шаардлага, нөхцөлийг давсан, төсвийн өндөр алдагдалтай, түүнд өрийн хүүний төлбөр дарамт учруулдаг нөхцөл байдал үүссэн, төлбөрийн тэнцэл өндөр алдагдалтайн дээр гадаад валютын нийт нөөц 1 тэрбум ам.доллар, цэвэр дүнгээр сөрөг түвшинд хүрээд байлаа.

Тухайн үед Монголбанк эдийн засагт үүссэн нөхцөл байдал дүн шинжилгээ хийж, эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэв. Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд

суларсан орчинд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамт өндөр байсны дээр 2016 оны сүүлийн 4 сард төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрахад дараах хүчин зүйлс нэмэлт дарамтыг бий болгов. **Нэгд,** Засгийн газар, Хөгжлийн банкны санхүүжилт болон Монголбанкны төсвийн шинж чанартай арга хэмжээний хүрээнд эдийн засаг дахь төгрөгийн нийлүүлэлт их хэмжээгээр нэмэгдээд байсан. **Хоёрт,** Мөн оны эхний хагаст Засгийн газраас хэрэгжүүлсэн “Сайн” хөтөлбөрүүдийг төв банкнаас санхүүжүүлээд байв. Энэ нь мөн эдийн засаг дахь төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, төгрөгийн ханш сулрах урьдач нөхцөлийг бүрдүүлсэн байв. **Гурав,** 2016 оны 6 дугаар сарын сүүлээр Эрдэнэт үйлдвэрийн 49 хувьтай холбоотойгоор дотоодын банкнаас их хэмжээний валют (нийт гадаад валютын нөөцийн 30 хувьтай тэнцэх хэмжээний) гадаад төлбөрт шилжүүлсэн байв. Өөрөөр хэлбэл, төгрөгийн их хэмжээний нийлүүлэлт хийгдсэн үед дотоодын банкнаас том дүнтэй валют бөөн дүнгээр гадагшилсан нь гадаад валютын хомсдолыг бий болгож, төгрөгийн ханш богино хугацаанд хүчтэй сулрахад анхны суурь том шалтгаан болов.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хөдөлгөөнөөс харахад 2013 болон 2016 онд хамгийн өндөр савлагаа гарчээ (Зураг 1). 2008 оны хямралын үед ажиглагдаагүй ханшийн хэлбэлзэл эдгээр онуудад ажиглагдсан нь төсвийн зардал, Хөгжлийн банкны санхүүжилт өндөр байсны дээр төв банк төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлснээс шалтгаалав. Монголбанк төсвийн шинж чанартай үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж, 2012 оноос 2016 оныг дуустал хугацаанд нийт 7 их наяд төгрөгийг банкуудад нийлүүлсэн явдал нь эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг алдагдуулж, ханш сулрах дарамтыг бий болгов.

Зураг 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн савлагаа¹




Эх сурвалж: Монголбанк

2012-2016 онд Монголбанкнаас хэрэгжүүлсэн төсвийн шинжтэй хөтөлбөрүүдийн нийт санхүүжилтийн 40 орчим хувь буюу нийт 2.2 их наяд төгрөг нь 2013 онд гарчээ. Энэ үед улсын нэгдсэн төсвийн зарлага, Хөгжлийн банкнаас олгосон санхүүжилт зэрэг төсвийн санхүүжилтийн нийт хэмжээ өмнөх оноос 34 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, төсвийн тэлэх бодлогын үед төв банкнаас төсвийн шинжтэй санхүүжилтийг нэмж олгосноор зах зээл дэх төгрөгийн нийлүүлэлтийг хэт тэлж, улмаар гадаад валютын эрэлтийг огцом нэмэгдүүлсэн нь 2013 онд төгрөгийн ханш 19 хувиар сулрах суурь шалтгаан байсан юм. Төсвийн шинж чанартай үйл ажиллагааг санхүүжүүлж байх үед төгрөгийн нийлүүлэлтээс үүдэлтэй ханш сулрах дарамтыг зөөлрүүлэх зорилгоор Монголбанк гадаад валютын нөөцөөс их хэмжээгээр зарж, гадаад валютын нөөцийн хүрэлцээт байдлыг алдагдуулаад байв. Тодруулбал, гадаад валютын цэвэр нөөцийн хэмжээ 2014 оны 11 дүгээр сараас эхлэн сөрөг дүнтэй болж, валютын захад нийлүүлэх боломжтой Монголбанкны эх үүсвэр шавхагдсан бөгөөд гадаад валютын цэвэр албан нөөц 2016 оны 2 дугаар сард **-815 сая** ам.доллар болж түүхэн доод түвшиндээ хүрч байв.

¹ Стандарт хазайлт


Зураг 2. Үнэ тогтворжуулах хөтөлбөр эхэлж, ханш огцом сулрав



Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн Монголбанкнаас 2016 онд “Сайн” хөтөлбөр, АСЕМ, чанаргүй активыг бууруулах хөтөлбөрүүдэд нийт 1.1 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон нь төв банкнаас олгосон нийт төсвийн шинжтэй санхүүжилтийн 26 орчим хувийг эзэлж байна. Монголбанкнаас хэрэгжүүлсэн төсвийн шинжтэй хөтөлбөрүүд нь анх нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулж, Монгол Улсын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоог жигд, тасралтгүй байлгах зорилгоор эхэлж байсан бол явц дунд төв банкны үндсэн зорилт, арга хэрэгсэл, хөтөлбөрүүдийн анхны зорилгоос хэт хазайсан төсвийн шинжтэй үйл ажиллагаанд шилжсэн байна. Энэ нь мөн л улсын

төсөв болон төсөвтэй адилтгах зардлын нийт дүн өмнөх оноос 28 хувь буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн үетэй давхцаж байв. Гадаад валютын нөөцийн хүрэлцээт байдал хангалтгүй, эдийн засгийн суурь үзүүлэлтүүд муудсан энэ үед төсөв, мөнгөний хэт тэлэх бодлогын нөлөөгөөр төгрөгийн нийлүүлэлт нэмэгдэж 2016 онд төгрөгийн ханш 25 хувиар сулрахад нөлөөлөв. Түүнчлэн зах зээлд их хэмжээний мөнгө нийлүүлснээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах, инфляцийг нэмэгдүүлэх дарамтыг өсгөж байсан бөгөөд уг эх үүсвэрийг зах зээлээс эргүүлэн татах өртгийг өсгөж, Монголбанкны алдагдлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байв.

Зураг 3. Төв банк интервенцээр ханшийг барьж, нөөц шавхагдав.²


Эх сурвалж: Монголбанк

Төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлж байх үед төгрөгийн ханшийг тогтвортой түвшинд байлгах зорилгоор банкуудад гадаад валют нийлүүлж байв. Интервенцийн үр дүнд ханш алгуур суларсан ч төв банкны албан нөөцийг шавхаж, өрөөр нөөцийг бүрдүүлэх шаардлагыг бий болгов. ОУВС-ийн тодорхойлолтоор цэвэр нөөц 2014 оны 5 дугаар сараас сөрөг түвшинд орсон бөгөөд 2016 оны төгсгөлд хамгийн доод түвшинд хүрч, одоог хүртэл сөрөг дүнтэй хэвээр байна (Зураг 3). Тухайн үед интервенцийг Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцэл, банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлээр санхүүжүүлж байжээ. Тус хэлцлийн эх үүсвэрийг интервенцийн зорилгоор ашиглаж байсан бөгөөд ашигласан эх үүсвэртээ Монголбанк хүүгийн

зардал төлж байгаа нь төв банкны алдагдлыг их хэмжээгээр нэмэгдүүлж байна.

Дотоодын банкуудтай 2014 оноос эхлэн урт хугацаат своп хэлцэл байгуулж эхэлсэн байв. Ингэхдээ 2016 он хүртэл төгрөг, ам.долларын эх үүсвэрийн хүүг тэнцүү байх нөхцөлтэй буюу “хэт хөнгөлөлттэй” нөхцөл бүхий үүсмэл хэрэгслүүдийг банкуудтай байгуулж, энэ нь төв банкны алдагдлыг огцом нэмэгдэхэд хүргэсэн. Өнгөрсөн хугацаанд нийт 2.9 тэрбум ам.долларын своп хэлцэл байгуулснаас тэнцүү хүүтэй хэлцэл 41 хувь буюу 1.2 тэрбум ам.долларыг эзэлж байна (Зураг 4).

² ОУВС-ийн аргачлалаар гадаад валютын цэвэр нөөцийг тооцохдоо нийт нөөцөөс нөөцийн дансны гадаад болон дотоод пассивын дүнг хасаж тооцсон. МБ-ны аргачлалаар гадаад валютын цэвэр нөөцийг тооцохдоо нийт нөөцөөс нөөцийн дансны зөвхөн гадаад пассивын дүнг хасаж тооцсон.

Зураг 4. Банкуудтай байгуулсан своп хэлцэл

Эх сурвалж: Монголбанк

2014-2015 онд Монголбанк Sumitomo Mitsui Banking Corporation (SMBC), Bank of Tokyo-Mitsubishi UFJ Ltd (BTMU), Samsung C&T Corporation (Samsung) зэрэг компаниудаас алтаар эргүүлэн төлөх нөхцөлтэйгөөр нийт 220 сая ам.долларын зээл авсан бөгөөд уг зээлийг 2016 оны 10 дугаар сард төлсөн. Үүнээс үзвэл ханшийг тодорхой хугацаанд торгоон барих зорилгоор гадаад валютын нөөцийг шавхсан нь урт удаан хугацааны туршид Монголбанкинд зардал, алдагдлыг авчрах алдаатай бодлого байв.

Зах зээлд оролцогч иргэд, аж ахуйн нэгжүүд улс төр, нийгэм, эдийн засагт үүсэж буй нөхцөл байдлыг ажиглах, нээлттэй байгаа статистик мэдээллийг олж авах, түүнд дүн шинжилгээ хийх чадвартай билээ. Нөгөө талдаа, төв банк өөрийн гаргадаг статистик мэдээллийг нийтэд үнэн бодитоор цаг тухайд нь хүргэх үүрэгтэй. Бодит нөхцөл байдал, статистик мэдээлэл нийтэд ил болох үед гадаад валют худалдан авахын төлөөх түр зуурын “сандрал” бий болсны дээр банкууд зарах валютын хэмжээндээ хязгаарлалт тогтоож байв. Гадаад валютын өндөр дүнтэй цэвэр гадагшлах урсгалтай, валютын нөөц нь 1 тэрбум ам.доллар байгаа нөхцөл байдалд Монголбанк валютын захад үргэлжлүүлэн идэвхтэй интервенци хийх боломжийг хязгаарлаад байв. Валютын томоохон дүнтэй орох урсгал тодорхой болоогүй үед төв банкнаас том дүнтэй интервенци хийх нь гадаад валютын бага хэмжээний нөөцийг үргэлжлүүлэн бууруулах тохиолдолд ханшийн хямралд хөтлөх үр дагавартай байв.

Гэхдээ Монголбанкнаас долларжилтын идэвхжилийг бууруулах, төгрөгийн ханшийн сулрах дарамтыг багасгахад шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэв. Тухайлбал, 2016 оны 8 дугаар сард бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 15 хувьд хүргэх шийдвэр гаргав. Энэхүү арга хэмжээ нь тодорхой хугацаанд үр дүнгээ өгч төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамтыг бууруулж, зах зээлд оролцогчдын итгэлийг сэргээх, валютын томоохон орох урсгалыг бий болгох хугацааг олгосон юм. Төгрөгийн үнэ цэнийг хамгаалах тус арга хэмжээ нь үндэсний мөнгөн тэмдэгт богино хугацаанд хүчтэй суларч, урт хугацааны тэнцвэрт түвшнээсээ хэт хазайх үед төв банкнаас хэрэгжүүлдэг стандарт арга хэмжээ билээ.

Монголбанк Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т орох, орсоны дараах үүрэг амлалтаа амжилттай хэрэгжүүлэн эдийн засгийн сэргэлтэд бодит хувь нэмэр оруулж байна. Монголбанк 2016 оны 8-9 дүгээр сард Засгийн газартай хамтран “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг боловсруулж, УИХ-аар батлуулж, Монголбанк уг хөтөлбөрийн хүрээнд инфляцийг тогтворжуулах, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүний зэрэгцээ Олон Улсын Валютын Сан (ОУВС)-тай уулзаж, урьдчилан зөвшилцөлд хүрч, хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэгтэйгээр 2016 оны 10 дугаар сард хүргүүлж байв. ОУВС-тай тухайн үед хийсэн уулзалт, хэлцэл маш хүнд байдалд байсныг энд онцлох нь зүйтэй. Тухайлбал, Монголын тал 2015 онд хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаж, яг хөтөлбөр тохирох шатанд цуцалсан, одоогийн Монголын эдийн засгийн нөхцөл байдал тухайн үеийнхээс илүү хүнд байдалд орсон тул хөтөлбөрт хамруулахад хүндрэлтэй зэрэг асуудлуудыг тавьж байв.

Тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлаас харахад, Монгол Улсад ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т орохоос өөр сонголт байгаагүй. Монголбанк тус хөтөлбөрт орох, орсоны дараах үүрэг амлалтаа амжилттай хэрэгжүүлэн эдийн засгийн сэргэлтэд бодит хувь нэмэр оруулж

байна. Энэхүү хөтөлбөрт орох шийдвэр нь эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөвт бүрэн хэмжээний дүн шинжилгээ хийсний үндсэн дээр үндэсний эрх ашиг, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нийтлэг эрх ашгийг харгалзан үзэж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ юм. Монголбанк эдийн засгийн нөхцөл байдалд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар иж бүрэн дүн шинжилгээ хийж, олон улсын санхүүгийн байгууллага, бусад доноруудын дэмжлэг, туслалцаагүйгээр эдийн засагт нүүрлээд байгаа хүндрэл, сорилтыг дангаар даван туулах боломж хомс байна гэсэн дүгнэлтэд хүрч, эдгээр шинжилгээ, дүгнэлтийг Засгийн газар, УИХ-д тухай бүр танилцуулж, зайлшгүй шаардлагатай зоримог шийдвэр гаргахад хамтран ажиллав.

Тухайн үед төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралтаас гадна Монгол Улсын цаашдын дунд, урт хугацааны төлөвт эрсдэл учрах нөхцөл байдал үүсээд байв. Ялангуяа, төсвийн болон гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, өрийн дефолтоос зайлсхийх асуудал том сорилт болж байлаа. Тухайлбал, Хөгжлийн банкны 580 сая ам.долларын эргэн төлөлт 2017 оны 3 дугаар сард, Хятадын Ардын банк (ХАБ) болон Монголбанкны хооронд байгуулсан төгрөг, юанийн своп хэлцлээр Монголын талын авч ашигласан юаний эргэн төлөлт 2017 оны 8 дугаар сараас эхлэх, Чингис бондын 500 сая ам.долларын эргэн төлөлт 2018 оны 1 дүгээр сард, Димсам бондын 1 тэрбум юань (160 орчим сая ам.доллар)-ий эргэн төлөлт 2018 оны 6 дугаар сард хийгдэхээр шил даран хүлээгдэж байлаа. Эдгээр өр төлбөрийг төлөхөд гадаад валютын нөөц хүрэлцэхгүй (өр, төлбөр нь 4 дахин давсан), валютын дотоодын зах зээл дээр ноцтой хүндрэл бий болгохоор байсан тул өрийг төлөхөд гадаад зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх, дахин санхүүжүүлэх зайлшгүй шаардлагатай байв. Гэхдээ эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, бодлогын сахилга бат алдагдаад байсан тул гадаад зах зээл дээр дахин санхүүжилт хийхэд эрэлт бага, хүү нь өндөр байхаар байсан тул дунд хугацааны өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй байв. Иймд гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, доноруудын хөнгөлөлттэй нөхцөл (урт хугацаатай, хямд хүүтэй)-тэй санхүүжилтээр төсвийн болон

төлбөрийн тэнцлийн хүндрэлийг даван туулж, эдийн засгийг богино хугацаанд сэргээх, эдийн засаг, санхүүгийн салбарт зайлшгүй шаардлагатай байсан реформуудыг мөн богино хугацаанд хийх үүднээс ОУВС-ийн хөтөлбөрт орох шаардлагатай байв.

ОУВС-тай хөтөлбөр тохирох сургаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжиж, гадаад валютын эх үүсвэрүүд төгрөг рүү хөрвөж эхэлсэн билээ. Олон сар үргэлжилсэн амаргүй хэлэлцээрийн үр дүнд Монгол Улсын Засгийн газар, ОУВС-тай "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх урьдчилан тохиролцоонд 2017 оны 2 дугаар сарын 19-ний өдөр хүрч чадсан. Ингэснээр 5.5 ам.долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг донорууд (ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон, Солонгосын засгийн газар, БНХАУ-ын төв банк зэрэг)-аас авах боломжийг бүрдүүлэв. Ийнхүү ОУВС-ийн хөтөлбөрт орох нь тодорхой болсны дараагаас дотоодын зах зээлд оролцогчид болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулагчдын эдийн засгийн төлөвийн талаарх итгэл сэргэж, бондуудын хүү буурч, дахин санхүүжилтийн зардал бага байхад эерэгээр нөлөөлсөн билээ. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлж, доноруудаас санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болсон мэдээ нь хөрөнгө оруулагчдын Монгол Улсын эдийн засгийн төлөвт итгэх итгэлийг сэргээж, хугацаа нь дуусахаар хүлээгдэж байсан Хөгжлийн банк, Засгийн газрын бондуудыг амжилттай дахин санхүүжүүлж, 2017 оны 8 дугаар сарын 21-нд хугацаа нь дуусахаар хүлээгдэж байсан Хятадын ардын банктай байгуулсан своп хэлцлийн хугацааг 3 жилээр сунгахаар болж, богино хугацааны өрийн дарамт буурав. Улмаар Монгол Улс дефолтоос зайлсхийсэн билээ. Хэрэв Монгол Улс гадаад өр төлбөр дээр дефолтод орсон бол гэрээний нөхцөлийн дагуу Монгол Улс Засгийн газрын 850 сая ам.доллар, арилжааны банкуудын гадаад өр болох 800 сая ам.доллар, нийт 1 тэрбум 650 сая ам.долларыг нэг өдөр нэг цагийн дотор эргүүлэн төлөх нөхцөл байдал үүсэх байсан билээ. Энэ тохиолдолд Монгол Улсын хөгжил 8-10 жилээр ухрах нөхцөл байдал үүсэхээр байв.

Монгол Улсын Засгийн газар, ОУВС-ийн хамтран хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлэхэд Монголбанк

бүх талаар дэмжин ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд тохирсон төв банкны дотоод цэвэр активын дээд хязгаар, гадаад цэвэр активын доод хязгаарын тоон зорилтууд болон урьдчилан авах хэмжээнүүдийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн хөтөлбөрийн үнэлгээг амжилттай хийлгэж ирлээ. Хөтөлбөрт орсноор эдийн засгийн сэргэлт эрчимжиж, эдийн засгийн дархлаа нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулагчдын Монголын эдийн засагт итгэх итгэл сэргэж, улмаар дефолтын эрсдэлээс зайлсхийж, хөтөлбөрийн хүрээнд тохирсон зорилтуудаа амжилттай хангаж байна.

Монголбанк гадаад валютын албан нөөцийн хэмжээг нэмэгдүүлж 3.8 тэрбум ам.долларт хүргээд байна. Гадаад валютын нөөцийн дотоод гол эх үүсвэр болох үнэт металлын худалдан авалтыг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгө, ханшийн бодлогыг хослуулан үр дүнтэй хэрэгжүүлэв. Үүний үр дүнд гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийг сүүлийн 2 жилд 3.8 дахин өсгөн импортын 9 орчим сарын хэрэгцээг хангах түвшинд хүргэн нэмэгдүүллээ. Монголбанк энэ хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлж буй Алт-2 хөтөлбөрт дэмжлэг үзүүлэн ажиллаж, алтны салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэх, алтыг орон нутаг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, энэ хүрээнд алтны сорьцын лабораторийг Дархан-Уул, Баянхонгор аймагт байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгээд байна. Монголбанк 2016 онд 18.6 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 22 тонн үнэт металл худалдан авч, энэ эх үүсвэрээс жил бүр 700-800 сая ам.долларыг бүрдүүллээ. Түүнчлэн томоохон экспортлогч компаниудтай хэлцэл хийх замаар гадаад валютыг худалдан авч, гадаад валютын нөөцийг арвижуулав. Тухайлбал, 2018 онд Оюу толгой ХХК-иас 282 сая ам.доллар, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 225 сая ам.доллар, Эрдэнэс тавантолгой ХК-иас 207 сая ам.доллар буюу нийт 714 сая ам.долларыг худалдсан авсан бол 2019 оны 4 дүгээр сарын 18-ны байдлаар Оюу толгой ХХК-иас 282 сая ам.доллар, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 150 сая ам.доллар, Эрдэнэс тавантолгой ХК-иас 200 сая ам.доллар, бусад аж ахуйн нэгжүүдээс 34 сая ам.доллар буюу нийт 666 сая ам.долларыг худалдан аваад байна. Үүний зэрэгцээ дотоодын банкуудын гадаад зах зээлээс

санхүүжилт татах зардлыг бууруулж, гадаад валютын дотогшлох урсгалыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

ГВАН нэмэгдсэн нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгт итгэх итгэлийг сэргээх, улсын эрсдэлийг бууруулж, зээлжих зэрэглэл нэмэгдэхэд нөлөөлсөн үндсэн хүчин зүйлсийн нэг байв. Тухайлбал, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2018 онд нэмэгдүүлж, Fitch болон S&P агентлагууд 2016 оны хүндрэлийн өмнөх түвшинд хүргэн сайжрууллаа. Монголбанк нь Засгийн газартай хамтран зэрэглэл тогтоогч байгууллагуудад эдийн засаг, гадаад валютын нөөц, санхүүгийн зах зээлд гарч буй эерэг өөрчлөлтүүд, тэдгээрийн суурь шалтгааныг тухай тайлбарлаж, зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлд нягт хамтран ажиллаж ирлээ.

Ийнхүү макро эдийн засгийн тогтвортой байдал, сэргэлт хангагдаж, зээлжих зэрэглэл нэмэгдсэн нь Засгийн газар, Хөгжлийн банк, Монголын Ипотекийн Корпораци болон бусад хувийн секторын гадаад зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх хүү бага байх, валютын дотогшлох урсгал нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлэв. Ийнхүү валютын дотогшлох урсгал нэмэгдэх нь эргээд ГВАН нэмэгдэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байхад ч эерэгээр нөлөөлж байна.

Гэхдээ ГВАН-ийн хүрсэн түвшинг том дүнтэй интервенци хийх замаар эргүүлээд үрэн таран хийх нь эдийн засгийн дунд хугацааны төлөвт эргээд маш ноцтой эрсдэлүүдийг бий болгоно гэж Монголбанк үзэж байна. Ялангуяа, гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр валютын ханш сулрах зах зээлийн нөхцөл бүрдсэн, сөрөг нөлөө нь харьцангуй удаан үргэлжлэхээр байгаа нөхцөлд интервенциэр ханшийг хүчээр барих оролдлого нь ГВАН-ийг шавхах л үр дагаварт хүргэхээр байна. Харин богино хугацааны хэт огцом хэлбэлзэлийг бууруулах, валютын ханш суурь нөхцөлтэй нийцтэй түвшинд байлгах чиглэлд Монголбанк валютын захад оролцож ирлээ. 2018 оны хувьд валютын дуудлага худалдаагаар 1.2 тэрбум ам.долларыг нийлүүлсэн бол 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар валютын дуудлага худалдаагаар 523 сая ам.долларыг нийлүүлээд байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2018 онд 8.9 хувиар суларсан нь импорт, гадаад өр төлбөр болон гадаад зах зээлд гарсан томоохон өөрчлөлтүүдтэй холбоотойгоор валютын захад илүүдэл эрэлт байж, сулрах хүлээлт давамгайлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамт өндөр байсны үр дагавар юм. Тухайлбал, 2018 онд валютын ханшид нөлөөтэй дараах гол өөрчлөлтүүд гарав:

- АНУ-ын Холбооны Нөөцийн Банк 2018 онд бодлогын хүүгээ нийт 4 удаа, өсгөж **2.50%**-д хүргэв. Ингэснээр гадаад зах зээлээс санхүүжилт бүрдүүлэх өртөг нэмэгдэж, төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансаар дамжин Монгол Улсад орох валютын урсгал хязгаарлагдмал болов.
- Монгол Улсын эдийн засаг сэргэж буйтай холбоотойгоор 2018 оны эхний 12 сарын байдлаар зээл олголт өмнөх оны мөн үеэс 24%, **импортын хэмжээ** 5.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс **36%-иар** өссөн нь валютын эрэлтийг нэмэгдүүлэх шалтгаан болов.
- Экспортын орлого 13%-иар өсч, цэвэр дүнгээр гадаад валютын эрэлт, нийлүүлэлтээсээ хурдтай өсөв. Түүнчлэн нүүрсний экспортын


50 орчим хувийг бүрдүүлдэг Гашуунсухайт боомтын үйл ажиллагаа 2018 он дуустал доголдсоноос шалтгаалан экспортын орлого тасалдаж, нүүрсний экспорт Монголбанкны төсөөллөөс 250 сая ам.доллараар бага гүйцэтгэлтэй гарлаа.

- Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд 2018 олгохоор шийдвэрлэсэн санхүүжилтийн гүйцэтгэл 400 сая ам.доллараар бага байв.

Эдгээр шалтгааны улмаас 2018 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт харьцангуй өндөр байлаа. Тодруулбал, 2018 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх оноос 8.9 хувиар, голлох 22 улсын валютын сагстай харьцах төгрөгийн ханш оны эхний 12 сарын байдлаар 2.8%-иар суларсан байна.

Гэхдээ 8.9 хувийн сулралт нь түүхий эд экспортлогч бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт бөгөөд Монголбанк ханшийн тогтвортой байдлыг хангахад анхаарч ажилласаныг илтгэнэ. Тухайлбал, ОХУ-ын рубль 21 хувиар, Казахстаны тэнгэ 14.4 хувиар, Австралийн доллар 10.8 хувиар суларч, гадаад шокын бодит секторт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг авч ажиллав (Зураг 5).

Зураг 5. Голлох валютуудын эсрэг ам.долларын ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмберг

Дэлхий дахинд ам.долларын ханш чангарч буй нөхцөлд Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг хүчээр тогтоон барих нь Монгол Улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж, гадаад худалдааны ашгийг бууруулж, улмаар ханшийн дарамтыг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй байв. Түүнчлэн гадаад болон дотоод эдийн засгийн суурь хүчин зүйлс төгрөгийн ханшийг сулруулах дарамттай үед Монголбанкнаас ханшийг тогтмол барих нь гадаад валютын нөөцийг бууруулж, УИХ-аас баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, ӨСХ-ийн хүрээнд Монголбанкны хүлээсэн үүргийг зөрчихөөр байв. Тухайлбал, ӨСХ-ийн хүрээнд хүлээсэн нэг амлалт нь Монголбанкны гадаад цэвэр актив буюу валютын цэвэр албан нөөцийг тохиролцсон дүнгээр шат дараатай нэмэгдүүлэх явдал юм. Урсгал тэнцлийн өндөр алдагдалтай орчинд энэхүү үүргийг биелүүлэх явдал туйлын хүнд байсан тул валютын зах дээрх оролцоог зарим үед хязгаарлах нөхцөл байдал ч үүсэж байв. Хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн энэхүү тоон зорилтыг бүрэн биелүүлэхгүй тохиолдолд Монгол Улс хөтөлбөрөөс гарахад хүрэх ноцтой үр дагавартай тул Монголбанк энэхүү тоон зорилтод хүрэх, ханшийн тогтвортой байдлыг хангах гэсэн хүнд сорилтыг нэгэн зэрэг хангах шаардлагатай тулгарч байв. Өөрөөр хэлбэл, нэг талдаа эдийн засгийн дархлааг хангах, эмзэг байдлыг бууруулах, нөгөө талдаа ханшийн хэт өндөр хэлбэлзлийг бий болгохгүй байх зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд Монголбанкны бодлого чиглэж ирлээ.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсгэхгүй байх хүрээнд 2018 онд гадаад валютын дуудлага худалдаагаар нийт 1.2 тэрбум ам.долларыг валютын захад нийлүүлэв. Гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ болон хугацаа харилцан адилгүй байдаг манай орны хувьд валютын эрэлтийг тогтвортой хангах, эрэлт, нийлүүлэлтийн түр зуурын шинжтэй зөрүү гаргахгүй байх үүднээс экспортлогч томоохон аж ахуйн нэгжүүдээс гадаад валютыг худалдан авч, уг валютыг захад ханшийн огцом хэлбэлзэл үүсгэхгүйгээр нийлүүлэх туршлагыг нэвтрүүлэв. Үүний зэрэгцээ 2018 оны 9, 11 дүгээр сард хуралдсан Мөнгөний бодлогын хорооны хурлаар гадаад валютын эрэлтийг бууруулах, төгрөгийн

харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх замаар төгрөгийн ханшийн хэлбэлзлийг бууруулах шийдвэрүүдийг гаргав. Тухайлбал, бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэх, гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлдэг хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах зорилгоор хэрэглээний зээлийн хугацааг 30 сараар хязгаарлах, хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байх, ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 30 пунктээр нэмэгдүүлж 150 хувьд хүргэх макро зохистой бодлогын арга хэмжээг авав. Түүнчлэн 28 долоо хоногтой Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ыг шинээр гаргахаар шийдвэрлэсэн нь төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлж, зэх зээл дэх илүүдэл төгрөгийн эх үүсвэрийг урт хугацаагаар татах замаар валютын эрэлтийг бууруулж, улмаар эрчимтэй суларч байсан төгрөгийн ханшийн сулрах дарамтыг бууруулав.

Олон улсын зах зээлд ам.долларын ханш чангарч, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа, дотоодын эдийн засгийн идэвхжил нэмэгдэхийн хэрээр төгрөгийн ханш сулрах дарамт өссөн хүндрэлтэй нөхцөл байдалд Монголбанк ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах, ОУВС-ийн тоон зорилтуудыг хангах, эдийн засгийн дархлааг сайжруулах зорилгоор валютын нөөцийг нэмэгдүүлэх зэрэг томоохон зорилтуудыг нэгэн зэрэг ханган ажиллаж байна. Улмаар 2019 оны 3 дугаар сарын байдлаар ГВУН-ийн хэмжээ сүүлийн 6 жилийн хамгийн өндөр түвшин болох 3.8 тэрбум ам.долларт хүрч өсөөд байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2019 оны эхний 4 сард тогтвортой байж, бага зэрэг чангараад байна.

Хэдийгээр Гаалийн Ерөнхий Газар (ГЕГ)-аас танилцуулдаг улсын хилээр нэвтэрсэн барааны гадаад худалдаа сүүлийн 5 жилд ашигтай байсан ч гадаад худалдааны мөнгөн урсгалаас үзвэл, гадаад худалдааны мөнгөн урсгал сөрөг буюу цэвэр дүнгээр валют гадагшилсан хэвээр байв. Энэ нь (i) экспортын бүтээгдэхүүний тодорхой хэсэг нь улсын хилээр гарсан ч борлуулагдахгүйгээр БНХАУ дахь агуулахад хадгалагддаг, (ii) экспортын зарим бүтээгдэхүүнд Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан байдаг, (iii) ГЕГ-ын статистикт нүүрсний экспортын дүнд улсын хил хүртэлх тээвэрлэлтийн зардлыг шингээж тооцдог. Гадны компаниуд

нүүрсний тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаатай холбоотойгоор Монгол Улсад орох мөнгөн урсгалд уг нүүрсний тээвэрлэлтийн орлого багтдаггүй, (iv) экспортын бүтээгдэхүүний орлогын тодорхой хэсэг нь гадаадын банк, санхүүгийн байгууллагын дансанд байршдаг зэргээс шалтгаалдаг. Тодруулбал, ГЕГ-ийн статистикаар 2018 онд гадаад худалдааны тэнцэл 1137 сая ам.долларын ашигтай гарсан бол гадаад худалдааны мөнгөн урсгал буюу банкны системээр дамжсан гадаад худалдааны тэнцэл **-304 сая ам.доллар** байв.

Монголбанк өргөн хэмжээний шинэчлэл, реформуудыг хэрэгжүүлж, макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүргээ амжилттай биелүүлж байна. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд банкны салбарт хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, арилжааны банкуудыг төлбөрийн чадварыг бодитойгоор тодорхойлох зорилгоор олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниар активын чанарын үнэлгээ /AQR/-г бүх банкуудад амжилттай хийлээ³. Энэ үнэлгээг Монгол Улс Ази тивийн орнуудаас анх удаа Европын холбооны төв банкны аргачлалын дагуу хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн нь Монголын банкны салбарт болон төв банкны хяналт шалгалтын тогтолцоонд томоохон дэвшил болов. Банкны систем ийнхүү олон улсын стандартын дагуу эрүүл мэндийн үзлэгт орсноор гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагууд, хамтын ажиллагаатай орнуудын итгэлийг хадгалахад чухал байв. Мөн банкны секторын үйл ажиллагааны стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, банкны системийн эрсдэл даах чадварыг дээшлүүлэхэд авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлох, улмаар эдийн засгийн хүндрэлээс богино хугацаанд гарч цаашид тогтвортой санхүүгийн зуучлалыг хадгалж эдийн засгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах банкны тогтолцоог хөгжүүлэхэд чухал алхам болов.

Активын чанарын үнэлгээний үр дүнд Монголын банкны салбар, систем тогтвортой байна гэсэн дүгнэлт хийсэн болно. Харин 1-2 банк дээр асуудал, хүндрэл үүсээд байсныг нийтэд нээлттэй

мэдээлсэн билээ. Активын чанарын үнэлгээний болон холбогдох бусад арга хэмжээний үр дүнг үндэслэн Монголбанкнаас төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, активын чанарын үнэлгээний үр дүнг банкуудын тайланд тусгах, чанаргүй активыг шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох, банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай буюу дахин хөрөнгөжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг ажлууд хийж байна. Эрүүл банкны салбартай байх нь эрүүл санхүүгийн салбар бий болгож, улмаар эдийн засгийн эрүүл суурь бүрдүүлэх тул банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, эрх зүйн орчинг сайжруулах талаар эрчимтэй ажиллаж байна.

Активын чанарын үнэлгээгээр банкуудын зээлийн багцын чанарыг үнэлэхээс гадна тэдгээрийн үйл ажиллагааны бодлого, журам, зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, барьцаа хөрөнгө, гуравдугаар түвшний хөрөнгө зэргийг үнэлэх ажиллагаа хийгдсэн болно. Түүнчлэн, банкууд өөрийн хөрөнгийн түвшинг 2021 он хүртэлх хугацаанд хангах талаар бизнес төлөвлөгөөг боловсруулан Монголбанкинд ирүүлэх нийтлэг шаардлагыг тавьж, санхүүгийн үзүүлэлтэд эрсдэлийн сорилын шинжилгээг хийх замаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний дутагдалыг тодорхойлсон болно. Үнэлгээний үр дүнг 2018 оны 2 дугаар сард олон нийтэд мэдээлсэн бөгөөд санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулахгүй байх зорилгоор өөрийн хөрөнгийн дутагдлыг системийн нийлбэр дүнгээр олон нийтэд зарлаж, дутагдалтай банкуудын нэрийг мэдээлээгүй. Өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан тул 9 сарын хугацаатай үүрэг даалгаварыг Монголбанкнаас өгч, 2018 оны 12 дугаар сард багтаан бүрэн хангасан байх шаардлагыг тавьсан болно.

Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэгт хугацаа дуусахад дутагдал илэрсэн банкуудаас Капитал банк ХХК шаардлагыг биелүүлээгүй байв. Тус банкны үйл ажиллагаа 2015 оны 10 дугаар сараас эхлэн доголдож, төлбөрийн чадваргүй болж эхэлсэн тул Монголбанкнаас зөрчил дутагдлыг арилгах, банкны засаглалыг сайжруулах талаар холбогдох хууль, журмын дагуу шат дараатай, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тухай бүр авч байв (Зураг 6).

³ Банкны салбар дээр активын чанарын үнэлгээ хийх, түүнд суурилсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд ӨСХ зогсох, улмаар Монгол улс гадаад өрийн дефолттой нүүр тулахаар байв.


Үүнд:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хугацаатай үүрэг даалгаврыг өгөх;
- Торгууль ногдуулах;
- Эрсдэлийн сан нэмж байгуулах;
- Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу зөрчлийн хэрэг үүсгэх;
- Банкны эрхлэх үйл ажиллагааны зарим зөвшөөрлийг зогсоож, зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгаврыг өгөх;
- Банкны удирдлага, зохион байгуулалт, үйл

ажиллагааны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

- ТУЗ болон Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг зогсоох;
- Зээл төлүүлэх, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байлгах;
- Зарим хөрөнгийг худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;
- Монголбанкны хянагч, тусгай төлөөлөгч томилох;
- Шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.

Зураг 6. Капитал банк ХХК-д авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

Капитал банк нь өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж чадаагүйгээс гадна, Монголбанкнаас Төв банк (Монголбанк)-ны тухай, Банкны тухай хуулийн дагуу авсан арга хэмжээний биелэлт хангагдаагүй, Банкны тухай хуулийн дагуу Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авах үндэслэлгүй байв. Тус банкны өр төлбөр нь активаасаа 279 тэрбумаар хэтэрсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 0.5 хувь болсноор хадгаламж эзэмшигч, харилцагч болон мөнгөн төлбөрийн шаардах эрх бүхий этгээдийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болж, банк хоорондын төлбөр тооцооны гүйлгээг саатуулж, банкны заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж чадахгүйд хүрч, цаашид хэвийн үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болсон тул дараагийн арга хэмжээг авах шаардлага үүссэн байв.

Иймд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, албадлагын арга хэмжээ авах”; 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтад “Монголбанкны Ерөнхийлөгч Банкны хяналт шалгалтын хорооны зөвлөмжийг харгалзан шийдвэр гаргах, арга хэмжээ авах”; Банкны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх боломжгүй тухай Монголбанкны шийдвэр гаргасан үндэслэлээр банкиг албадан татан буулгах шийдвэр гаргаж, банкны эрх хүлээн авагч томилоно” гэснийг тус тус үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар Капитал банкиг албадан татан буулгах шийдвэр гаргаж, банкны эрх хүлээн авагчийг томилов.

Капитал банкинд байршиж байсан төрийн сангуудын мөнгө нь банк төлбөрийн чадварын хүндрэлд орохоос өмнө (2016 оноос өмнө) тус банкинд аль хэдийн байршиж байсан бөгөөд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон үеэс албадан татан буулгах хүртэл хугацаанд

Монголбанк дээр дурдсанчлан хуулийн дагуу авах ёстой арга хэмжээнүүдийг шат дараатай авсаар ирсэн болно.

Банкны эрх хүлээн авагч томилогдсоноор Капитал банкны үйл ажиллагааг зогсоон, тус банкны тайлан тэнцэл, хөрөнгийг хүлээн авахаар ажиллаж байгаа бөгөөд харилцах, хадгаламж эзэмшигчдийн нөхөн төлбөр Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Банкны тухай хуульд зааснаар шийдвэрлэгдэнэ. 20 сая төгрөгөөс доош дүнтэй харилцах, хадгаламж эзэмшигчдийн нөхөн төлбөрийг ойрын хугацаанд Хаан банкаар дамжуулан олгох ба даатгалын нөхөн төлбөрийг Хадгаламжийн даатгалын сангийн эх үүсвэрээс яаралтай олгохын тулд Хаан банк, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран ажиллаж байна. Харин 20 сая төгрөгөөс дээш дүнтэй харилцах, хадгаламж эзэмшигчдийн нэхэмжлэлийг Банкны эрх хүлээн авагч 2019.04.22-ны өдрөөс эхлэн хүлээн авна. Капитал банк нь банкны системийн 1.1 хувийг бүрдүүлдэг байсан бөгөөд системийн нөлөө бүхий банк биш тул эдийн засаг дахь санхүүгийн зуучлалд сөрөг нөлөө үзүүлээгүй бөгөөд банкны систем үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж байна. Монголбанк үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг ханган ажиллаж байна.

Монголбанк зохистой засаглал, бодлогын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлснээр дунд болон урт хугацаанд тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх боломж нээгдэж, эдийн засгийн болон санхүүгийн хямралд өртөхгүй байх хөшүүрэг бүрдэнэ гэж үзсэн. Иймд 2017 оны эхээр Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийг 2017-2019 оны хооронд хэрэгжүүлэхээр баталж, сүүлийн 2 жил гаруй хугацаанд амжилттай хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь i) хууль, эрх зүйн орчинг сайжруулах, ii) засаглал, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, iii) хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, iv) дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, v) хамтын ажиллагааг бэхжүүлэх гэсэн үндсэн таван чиглэлд тулгуурлаж байгаа болно.

Сүүлийн 2 жил гаруй хугацаанд банк санхүүгийн системд хууль эрх зүйн шинэчлэлийг амжилттай эхлүүлээ. Банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль зэрэг санхүүгийн салбарын суурь багана болсон эрх зүйн актуудыг боловсронгуй болгох үүднээс нэмэлт өөрчлөлтийн төслийг эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж, УИХ-аар батлуулаад байна. Үүний зэрэгцээ банкны хяналт шалгалтын үйл ажиллагааг олон улсын стандарт болон шилдэг туршлагад нийцүүлэх, банкны салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, банкны бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор төсөв болон төрд ирж болзошгүй санхүүгийн зардлыг бууруулах зэрэг нэмэлт өөрчлөлтийг хууль эрх зүйн актад тусгалаа. Эдгээр хуулиудыг шинэчлэн батлуулснаар Төв банкны сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэн, бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг болж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болсон нь санхүүгийн салбарт болсон чухал үйл явдал байлаа. Энэ нь мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, банкны салбарыг илүү эрүүл, чийрэг байлгах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, эдийн засгийг тогтворжуулах, санхүүгийн секторт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монголбанк мөнгө, ханшийн бодлогоос гадна макро зохистой бодлого хэрэгжүүлдэг болж, бодлогын арга хэрэгслүүдээ өргөжүүлж, тэдгээрийг үр ашигтай ашиглаж байна. Үүний үр дүнд төв банкны үндсэн зорилт болох инфляцийг зорилтот түвшинд байлгах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлогыг амжилттай хэрэгжүүлж ирлээ.

Хууль эрх зүйн шинэчлэлээс гадна төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран дунд хугацааны бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Монголбанк манлайлан ажилласаар байна. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд “Зээлийн хүү бууруулах стратеги 2018-2023”-ийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөр батлуулж, бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхлээд байна. Үүнээс гадна санхүүгийн салбарыг хөгжүүлэх зорилгоор “Монгол

Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран баталж, арга хэмжээ хэрэгжүүлж байна. Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд Макро зохистой бодлогын стратегийг батлан системийн шинж чанартай эрсдэлийг бууруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Түүнчлэн Монголбанк өмнөх жилүүдэд хуримтлагдсан чанаргүй зээлийг зохистой арга замаар шийдвэрлэх зорилгоор “Чанаргүй зээлийг шийдвэрлэх стратеги”-ийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөр хэлэлцүүлэн батлуулав. Уг стратегийн хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Засгийн газартай хамтран ажиллаж байна. Монголбанкнаас банкуудын чанаргүй зээлийг шийдвэрлэх журмыг боловсруулах, чанаргүй зээлийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх ажлууд хийгдэж байна.

Монголбанк сүүлийн 2 жил гаруй хугацаанд эдийн засгийн сэргэлт, түүний хүртээмжтэй байдлыг хангахад бодит хувь нэмэр оруулж байна. Төв банкны үндсэн зорилт болох инфляцийг зорилтот түвшинд байлгах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих мөнгөний болон ханшийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж ирлээ.

Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэг-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Энэхүү зорилтыг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд инфляцийн зорилтот түвшинг хангах гэж тодорхойлдог. Үндсэн чиглэлд инфляцийн зорилтыг 2016 онд 7 хувь, 2017-2019 онуудад 8 хувь байхаар тогтоосныг Монголбанк бүрэн хангаж ирэв. Тухайлбал, 2016 оны эцэст 1.1 хувь байсан улсын инфляци алгуур өсч, 2017 оны эцэст 6.4 хувь, харин 2018 оны эцэст улсын хэмжээнд 8.1% байсан нь Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлд “Монголбанк инфляцийг 2018-2020 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулна” гэж тодорхойлсон зорилттой нийцтэй байв.

Инфляци 2016 онд бага түвшинд байсан нь эдийн засгийн уналтаар тайлбарлагдах бөгөөд дефляци эсвэл хэт бага түвшний инфляци нь эдийн

засгийн идэвхжилд сөрөг нөлөөтэй. 2014 оноос хойш үргэлжилсэн эдийн засгийн хүндрэлийн үед зах зээл дээрх эрэлт буурч, үнийн түвшний өсөлт зогсонги байдалд орж дефляцийн эрсдэл нүүрлээд байв. Эдийн засаг царцанги байдалд ороод байсныг өрхийн бодит орлого 2014 оноос эхлэн 12 улирал дараалан хумигдсан, банкны системийн зээл 2015 оны 7 дугаар сараас эхлэн 10 сар дараалан буурч, Дотоодын нийт бүтээгдэхүүн 2016 оны 3 дугаар улиралд 6 хувь агшсан зэргээс дүгнэж болно.

Монголбанк ханшийн сулралт, инфляцийн хөөрөгдлийг бий болгох, санхүүгийн тогтворгүй байдалд өндөр эрсдэл үүсгээд байсан төсвийн шинж чанартай санхүүжилтүүдийг 2016 оны 9 дүгээр сард бүрэн зогсоов. Харин мөнгөний бодлогыг үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилгод чиглүүлж, зах зээлийн зарчмаар хэрэгжүүлэхийн зэрэгцээ инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлэх Бодлого төсөөллийн шинжилгээний системийг эрчимтэй хөгжүүлэх, Мөнгөний бодлогын хороо буюу хамтын зарчмаар бодлогын шийдвэрийг гаргах ажлыг эрчимтэй нэвтрүүлж, олон улсад төв банкууд

мөнгөний бодлогыг хэрхэн хэрэгжүүлдэг тэрхүү жишигт нийцтэй ажиллаж байна.

Харин сүүлийн 2 жилд инфляци алгуур өссөн нь эдийн засгийн сэргэлтээр тайлбарлагдана. Монголбанк нийт эдийн засагт чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг тул улсын инфляцийг зорилтот түвшиндээ байлгахыг зорьж ажилладаг. Улаанбаатар хотын инфляци 2018 оны 12 дугаар сард буюу түр хугацаанд 9.7 хувьд хүрч, эргээд буурав. Энэхүү инфляцийн 5.4 нэгж хувь нь шатахуун, хатуу түлш болон махны үнийн өсөлт буюу нийлүүлэлтийн шинж чанартай үнийн өсөлтөөр голлон тайлбарлагдаж байв. Мөнгөний бодлогоор нийлүүлэлтийн шалтгаантай түр зуурын инфляцид хариу арга хэмжээ авах нь ажил эрхлэлт, үйлдвэрлэл буурахад сөргөөр нөлөөтэйн дээр инфляци эргэн буурах төсөөлөлтэй байв. Монголбанкны төсөөлөл бодит байдалд нийцтэй байж, инфляци буурч, 2019 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар Улаанбаатар хотод 7.5 хувь, улсын хэмжээнд 6.9 хувьтай буюу зорилтот түвшинд хадгалагдаж байна (Зураг **).

Зураг 7. Жилийн инфляци (Улс)



Зураг 8. УБ хотын жилийн инфляци



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны мөнгөний бодлого нь дунд хугацаанд инфляцийн хэлбэлзлийг тогтворжуулж, зорилтот түвшинд нь байлгахыг зорьж байна. Эдийн засаг хүндрэлээс гарч, сэргэлтийн замдаа яваа энэ үед инфляцийг дунд, урт хугацаанд зорилтот

түвшинд тогтвортой байлгахад чиглэсэн бодлого баримталж байна. Монголбанк Макро зохистой бодлогыг хэрэгжүүлж эхэлсэнээр дан ганц мөнгөний бодлогын арга хэрэгслээр удирдах боломжгүй байсан эрсдэлүүдийг удирдаж, мөнгөний бодлого

илүү үр дүнтэй хэрэгжих, санхүүгийн системд эрсдэл хуримтлахаас сэргийлэх боломж бүрдээд байна.

Дэлхийн эдийн засаг, түүхий эдийн зах зээл дээрх таатай байдал, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр, төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн шийдвэртэй арга хэмжээний үр дүнд эдийн засаг сэргэж байна. 2017, 2018 онуудад эдийн засагт тулгарч байсан олон сорилтыг амжилттай даван туулж, эдийн засаг сэргэсэн, банк санхүүгийн салбарт реформ хийсэн шинэчлэлийн жилүүд болж өнгөрлөө. Тухайлбал, 2018 онд мөнгө, зээлийн зохистой өсөлтийг хангаснаар инфляци зорилтот түвшнээс бага буюу 7.3 хувьтай, харин эдийн засаг 6.9 хувиар өсч, сэргэлт эрчимжиж байна. Эдийн засагт гарсан нааштай, эерэг нөхцөл байдалд тулгуурлан зээлийн хүүг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 оны эцэст 16.9 хувь болж, сүүлийн 6 жилийн хамгийн бага түвшинд хүрлээ. Зээлийн хүүний бууралтын нөлөөгөөр банкуудын бизнесийн зориулалттай, төгрөгөөр олгосон зээл өнгөрсөн

онуудтай харьцуулахад өндөр хувиар өслөө. Энэ нь бизнес эрхлэгчдийн дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байр, үйлдвэрлэл өсөхөд чухал түлхэц болов.

Монголбанк бодит эдийн засгийг мөнгөний бодлогоор дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг 2017, 2018 онд шат дараатай бууруулснаар банкны салбараас бодит эдийн засаг руу нийлүүлэгдэх санхүүжилт нэмэгдэж эдийн засгийн сэргэлтэд чухал дэмжлэг боллоо. Улмаар хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт болон импортын өсөлт эрчимжиж, эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээр 2018 оны турш сар бүрийн инфляцийн 3-4 нэгж хувийг эрэлтийн шинж чанартай инфляци бүрдүүлсэн байна. 2018 онд иргэд, аж ахуйн нэгжийн орлого нэмэгдэн, татварын орлого 30 хувь сайжирсан, ажилгүйдэл 2018 оны 4-р улиралд сүүлийн 13 улирлын доод түвшин буюу 6.6% болж буурсан, санхүүгийн зуучлал нэмэгдэн банкны зээлийн өсөлт 2018 онд 20% давсан, бизнесийн зээлийн өсөлт 17%-д хүрсэн зэрэг нь бодит эдийн засаг дээр ч, санхүүгийн зах зээл дээр ч сэргэлт бий болсны илэрхийлэл юм (Хүснэгт 1).


Хүснэгт 1 Эдийн засгийн сэргэлтийг илэрхийлэх гол макро үзүүлэлтүүд

	Уналтын доод үе	Сэргэлтийн үед
Инфляци	↘ Дефляци (2016Q3-Q4)	↗ Инфляци 7.3% (2019M1)
ДНБ-ийн өсөлт	↘ -1.4% (2016Q3, 4 улирал); -6.0% (2016Q3)	↗ +6.9% (2018); +8.1% (2018Q4)
Ажилгүйдлийн түвшин	↗ 11.6% (2016Q1)	↘ 6.6% (2018Q4)
Өрхийн бодит орлого	↘ 2014Q1-2016Q4 хооронд дараалсан 12Q	↗ 2017Q1-ээс өссөн; 7.4% (2018Q4)
Хувийн хэрэглээ	↘ 2016Q2-2016Q3	↗ 3.3% (2018Q4)
Хөрөнгө оруулалт	↘ Дунджаар -18.3% (2013Q1-2015Q4)	↗ 27.2% (2018)
Валютын нийт нөөц	↘ \$1 тэрбум	↗ \$3.6 тэрбум (2019.2)
Төлбөрийн тэнцэл	↘ -\$2.6 тэрбум (2013-2016)	↗ +\$1.32 тэрбум (2017-2018)
Зээлжих зэрэглэл	↘ Унасан (2014-2016)	↗ Сайжирсан (2018)
Төсвийн тэнцэл	↘ -₮1.4 их наяд (2011-2017 оны дундаж)	↗ +11.9 тэрбум (2018)
Зээлийн хүү (ЖДХ)	↗ 20%+	↘ 16.9% (2018.12)
Зээлийн өсөлт	↘ -5% (2015.07-2016.05)	↗ +24% (2018)

Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлт (M2)-ийн өсөлт 2016 онд 21 хувь, 2017 онд 30.5 хувь, 2018 онд 22.8 хувь байсан бөгөөд 2019 оны 3 дугаар сарын байдлаар 19.7 их наяд төгрөгт хүрээд байна. Харин зээлийн өсөлт 2016 онд 6.1 хувь, 2017 онд 9.6 хувь, 2018 онд 26.5 хувьтай байв.

Зураг 9. M2 өсөлт – Эх үүсвэр талаас




Мөнгөний нийлүүлэлт, зээл нь хэт бага эсвэл өндөр хувиар өсөх нь эдийн засагт сөрөг үр дагавартай. Ялангуяа, хэт өндөр хувиар өсөх нь инфляци өсөх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамтыг нэмэгдүүлдэг. Харин хэт бага хувиар өсөх нь эдийн засгийн идэвхижилд сөрөг нөлөөтэй. Монголбанкны зүгээс инфляци дахь эрэлтийн талын дарамт харьцангуй бага явж ирсэн тул мөнгө, зээлийн өсөлт нь хэт өндөр бус, харин эдийн засгийн идэвхжилийг дэмжих түвшинд явж ирсэн гэж үзэж байна. Хэрэв зээлийн өсөлт дээр дурдсан түвшнээс бага байх тохиолдолд эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлөх байв.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн шалтгаан нь эх үүсвэр талаас иргэд, аж ахуйн нэгжийн харилцах, хадгаламж өссөнтэй холбоотой байсан⁴

⁴ Экспортын орлого болон ГШХО нэмэгдэж, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн санхүүжилт орж ирсэн нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чухал эх үүсвэрүүд болов. Тухайлбал, экспортын орлого нэмэгдэж 2018 онд 7 тэрбум ам.долларт хүрсэн бол, 2017 оноос эхлэн Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт орж ирж, 2018 онд санхүүжилтийн хэмжээ 50% нэмэгдэн 1.2 тэрбум ам.долларт хүрэв. ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд 900 гаруй сая гаруй ам.долларын санхүүжилт орж ирээд байна.

Сүүлийн 2 жилийн мөнгө, зээлийн өсөлт нь эдийн засгийн идэвхжил сайжирч, санхүүгийн зуучлал нэмэгдсэнийн үр дүн гэдгээрээ онцлогтой бөгөөд инфляци болон төгрөгийн ханшид хүчтэй сөрөг дарамт учруулаагүй, тогтвортой өсөлт байв.

Зураг 10. M2 өсөлт байршуулалт талаас



Эх сурвалж: Монголбанк

бол байршуулалт талдаа банкны салбарын зээлийн өсөлтөөр голлон тайлбарлагдаж байна. Өөрөөр хэлбэл, банкны систем эдийн засагт мөнгийг үржүүлэх үүргээ сайн гүйцэтгэж, санхүүгийн зуучлал нэмэгдсэнээр эдийн засгийн сэргэлтэд эерэгээр нөлөөлж байна. Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь нарийвчлан авч үзвэл Засгийн газрын цэвэр зээл буурч, харин бизнесийн зээлийн өсөлт 2018 оны эцэст 17%-д хүрсэн нь томоохон эерэг өөрчлөлт юм (Зураг 11). Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд банкны санхүүжилтийн бүтэц өөрчлөгдөж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бизнесийн зээлийн өсөлт нэмэгдэв.

Зураг 11. Банкны секторын зээлийн өсөлт



Зураг 12. Бодлогын хүү ба зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Инфляцийн дарамт багатайгаар M2 мөнгө болон зээлийн хэмжээний ДНБ-нд эзлэх хувь хэмжээ өсөх нь санхүүгийн зуучлал гүнзгийрч буйг илэрхийлэх эерэг үзүүлэлт юм. Эдийн засагт санхүүгийн зуучлал нэмэгдэж, Төв банк бодлогын сахилга батыг хадгалж, сайн жишгээр бодлого хэрэгжүүлж ирсэн тул сүүлийн 2 жилийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг эрүүл өсөлт гэж дүгнэж болох юм. Монгол Улсын хувьд M2/ДНБ харьцаа 2018 оны эцсийн байдлаар 60 хувь дотор байгаа нь манай улстай ижил буюу доод

дундаж орлогын түвшин (lower middle income)-тай орнуудын дундаж 67.7 хувиас бага байна. Энэхүү үзүүлэлт өндөр орлоготой улс орнуудын хувьд 121.2% байдаг бөгөөд санхүүгийн зах зээл өндөр хөгжсөн Японд 242.4 хувь, Хонг-Конгт 376.5 хувь байна⁵. Иймд цаашид Монгол Улсад санхүүгийн зах зээл хөгжиж, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн хэрээр мөнгөний нийлүүлэлт өсөх шаардлагатай бөгөөд гагцхүү эрүүл, тогтвортой замаар энэхүү өсөлт бий болох шаардлагатай юм.

⁵ 2016 оны байдлаар. Эх үүсвэр Дэлхийн банкны өгөгдлийн сан.

ШИГТГЭЭ 1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ, ТҮҮНИЙ ШАЛТГААН


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь нэгдүгээрт эдийн засгийн тэлэлт, түүнийг тэтгэсэн зээлийн өсөлт; хоёрдугаарт гадаад валютын нөөцийн хуримтлал (гадаад цэвэр активын өсөлт)-тай холбоотой байна. Энэхүү өсөлтийг жишиг болохуйц бусад орнуудтай харьцуулахад нийцтэй түвшинд хадгалагдаж байна.

M2 мөнгө 2018 оны эцсийн байдлаар 23 хувиар өсч, 19.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд актив талаас үүний 9 нэгж хувийг гадаад цэвэр активын өсөлт, 22 нэгж хувийг иргэд болон ААН-д олгосон зээлийн өсөлт бүрдүүлж байна. (Зураг 1) Харин төсвийн төлөв 2018 онд чангарснаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлсэн юм. Мөнгөний нийлүүлэлтийн пассив талаас иргэд, ААН-ийн төгрөгийн харилцах болон хадгаламж нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон тайлбарлаж байна. (Зураг 2)

Мөнгөний нийлүүлэлтийн 2017 болон 2018 оны өсөлт нь хэдийгээр 2013 оны эцэс, 2014 оны эхэн үеийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлттэй ойролцоо түвшинд байгаа боловч, өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс, түүний макро эдийн засгийн төлөв болон тогтвортой өсөлтөд үзүүлэх нөлөө нь ялгаатай байна. Монголбанк 2013-2016 онуудад Засгийн газартай хамтран олон тооны төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байсны зэрэгцээ төсвийн алдагдал өндөр байсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлж байв. Харин гадаад орчны таагүй нөлөөгөөр гадаадын хөрөнгө оруулалт буурч, экспортын орлого багассанаар гадаад цэвэр актив огцом агшиж, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах нөлөө үзүүлж байв. Зээлийн өсөлт 2013 онд жилийн 59 хувьд хүрч эрчимжин, санхүүгийн зах зээлд хэт халалтыг үүсгэж байсан бол 2015-2016 онд хувийн секторт олгосон зээл хумигдаж, мөнгөний нийлүүлэлт болон эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө.


Харин, 2017-2018 онд гадны шууд хөрөнгө оруулалт, экспортын орлого нэмэгдэж улмаар гадаад цэвэр актив нэмэгдсэнээр мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эерэгээр нөлөөлж эхлээд байна. Нөгөө талаас, Монголбанк нь Засгийн газартай хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хумьж, төсвийн алдагдал буурч, 2018 онд төсөв ашигтай гарснаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг нэмэгдүүлэх нөлөө нь саарлаа. Үүний зэрэгцээ, иргэд, ААН-ийн төгрөгийн харилцах, хадгаламжийн дүн сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байгаа нь банкны эх үүсвэрийг нэмэгдүүлж, хувийн салбарт олгох зээлийг голчлон санхүүжүүлж байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг ийнхүү дотоод болон гадаад актив тэнцвэртэй бүрдүүлж байгаа нь макро эдийн засгийн дотоод болон гадаад тэнцвэрийг хамгаалж, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжиж байна.

M2 мөнгөний өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



Эх сурвалж: Монголбанк


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь эдийн засгийн тэлэлт, макро эдийн засгийн гол үзүүлэлтийн өсөлттэй нийцтэй байна. Монгол Улсын эдийн засаг сүүлийн 10 жилд эрчимтэй тэлж, 2010 онд 9.8 их наяд төгрөгтэй тэнцэж байсан бол нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2015 онд 23.2 их наяд төгрөг, 2018 онд 32.2 их наяд төгрөгт хүрчээ. Эдийн засгийн тэлэлттэй уялдан нийт мөнгөний эрэлт нэмэгдэж, M2 мөнгө 2010 оны эцэст 4.7 их наяд төгрөг байсан бол 2015 оны эцэст 10.0 их наяд төгрөг, 2018 оны эцэст 19.5 их наяд төгрөгт хүрээд байна. Мөн нийт зээлийн үлдэгдэл 2010 оны эцэст 3.3 их наяд төгрөг байсан бол 2015 оны эцэст 11.7 их наяд төгрөг, 2018 оны эцэст 17.2 их наяд төгрөг боллоо. Мөнгөний нийлүүлэлт өсч, эдийн засагт нийлүүлэх зээлийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр хөрөнгө оруулалт тэлж, 2010 онд 4.1 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан нийт хөрөнгө оруулалт 2015 онд 6.1 тэрбум төгрөг, 2018 онд 13.6 тэрбум төгрөгт хүрч, эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна. Мөн дотоодын нийт бүтээгдэхүүн, нэг хүнд ногдох орлого өссөнөөр өрхийн хэрэглээ тэлэв. Тухайлбал, 2010 онд нэг өрхийн жилийн дундаж зарлага 5.7 сая төгрөг байсан бол 2015 онд 12.4 сая төгрөг, 2018 онд 14.4 сая төгрөг болж нэмэгдээд байна.

Мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь 2000-04 онд дунджаар 30 хувь, 2005-09 онд 40 хувь, 2010-14 онд 48 хувь, 2015-18 онд 53 хувь болж нэмэгдсэн буюу манай санхүүгийн зах зээлийн гүнзгийрэлт сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж байна. Харин мөнгөний нийлүүлэлтийн сүүлийн 4 жилийн дундаж өсөлт өмнөх 15 жилийн дундаж өсөлтөөс бага байна.

M2 мөнгөний жилийн өсөлт




M2 мөнгөний ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ч бага, дунд орлоготой орнууд болон нэг хүнд ногдох ДНБ-ээр ойролцоо орнуудын дундажтай харьцуулахад бага байгаа бол манай оронтой өрсөлдөх чадвараар ойролцоо орнуудын дундажтай ижил түвшинд байна.


M2 мөнгөний нийлүүлэлт (ДНБ-д эзлэх хувиар)



№	Бүлгийн нэрс	Улсуудын нэрс
1	Экспорт давамгайлсан улсууд	Чили, Перу, Гана, Өмнөд Африк, Казахстан, Армэн, Узбекистан
2	Монгол улстай 1 х.н ДНБ ойролцоо орнууд	Армэн, Боливи, Өмнөд Африк, Перу, Египт, Босни ба Херцеговина
3	Монгол улстай өрсөлдөх чадварын индекс ойролцоо орнууд	Киргиз, Босни ба Херцеговина, Египт, Гана, Пакистан, Бүгд Найрамдах Доминикан улс, Сенегал, Ливан, Тунис
4	Далайд гарцгүй орнууд	Азербайжан, Боливи, Ботсвана, Молдав, Непал, Узбекистан, Туркменистан, Казахстан, Эсватин

Мөн хувийн секторт олгосон зээлийн хэмжээг ДНБ-д эзлэх хувиар нь хэмжиж үзвэл дундаас дээш орлоготой орнууд болон 1 хүнд ногдох ДНБ-ээр ойролцоо орнуудын дунджаас харьцангуй бага байгаа бол уул уурхайн экспорт өндөртэй орнуудын дундажтай ойролцоо түвшинд, өрсөлдөх чадварын индекс ойролцоо орнууд болон далайд гарцгүй орнуудын дунджаас бага зэрэг өндөр байна .


Хувийн секторт олгосон зээл (ДНБ-д эзлэх хувиар)



Эх сурвалж: Дэлхийн банк

Монголбанк нь гадаад валютын нөөцийг бүрдүүлэх зорилгоор алт худалдан авч, төгрөг нийлүүлдэг бөгөөд энэхүү төгрөгийн нийлүүлэлтийн сөрөг нөлөөг бууруулах зорилгоор интервенци-стерлизацийн бодлого хэрэгжүүлдэг. Энэхүү стерлизацийг хийхээс гадна мөнгө, зээлийн нийлүүлэлтийг хянах зорилгоор Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ыг мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болгон ашигладаг. ТБҮЦ, түүний хүү нь банк хоорондын захын илүүдэл нөөц, мөнгөний нийлүүлэлт, хадгаламж, зээлийн хүүнд нөлөөлж, мөнгөний бодлогын зорилтыг хангахад ашиглагддаг үндсэн хэрэгслүүдийн нэг юм.

Зураг 13. Төв банкны үнэт цаас, ЗГ-ын үнэт цаас



Эх сурвалж: Монголбанк

Төв банк мөнгөний бодлогыг бодлогын хүүгээр дамжуулан хэрэгжүүлэхийн тулд банкны систем дэх илүүдэл нөөцийг бага түвшинд байлгахын тулд нээлттэй захын үйл ажиллагаа явуулж ажилладаг. Нөгөө талдаа зохистой харьцааны тусгай шаардлагын дагуу банкууд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25 хувиас багагүй хэсгийг хөрвөх чадвар өндөртэй активт байршуулах ёстой байдаг. Энэ шаардлагыг хангах үүднээс банкууд дотоод зах зээл дээрх эрсдэлгүй, хөрвөх чадвар өндөртэй үнэт цааснууд болох ТБҮЦ болон Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг эзэмшдэг. Ялангуяа, ЗГҮЦ-ыг худалдан авч, зээл олгосны дараа үлдэж буй чөлөөт эх үүсвэрээр ТБҮЦ-ыг худалдан авах практик ажиглагддаг. Гэвч Засгийн газар үнэт цаас гаргахаа 2017 оноос зогсоосон болон бусад шалтгаанаар ТБҮЦ-ны эрэлт өсөөд байна (Зураг 13).

ТБҮЦ-ны үлдэгдэл 2019 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 4.7 их наяд төгрөгтэй тэнцүү байна. Засгийн газар 2017 онд 3.1 их наяд төгрөгтэй

тэнцүү хэмжээний үнэт цаас гаргаж, энэ хэмжээгээр ТБҮЦ-ны эрэлт, хэрэгцээ бага байв. Харин 2017 оны сүүлээс эдийн засгийн сэргэлтийг даган төсвийн орлого нэмэгдэж, ӨСХ-ийн хүрээнд олон улсын байгууллагууд, донор орнуудаас хөнгөлөлттэй гадаад санхүүжилт орж ирсэн тул Засгийн газар 2017 оны 11 дүгээр сараас хойш дотоодын зах зээлд ЗГҮЦ гаргахаа зогсоосон. Түүнчлэн ЗГҮЦ-ны хугацаа дуусах бүрт банкуудад эргэн төлөлтийг тухай бүр хийж ирсэн. Энэ бодлого, арга хэмжээ нь хэт өндөр түвшинд хүрч, төсөвт эргэн дарамт учруулж буй засгийн газрын өрийг шат дараатай бууруулах зорилтоос үүдэлтэй бөгөөд ӨСХ-ийн хүрээнд Монгол Улсын хүлээж буй нэг том үүрэг, зорилт билээ. Ийнхүү ЗГҮЦ-ыг шинээр гаргахаа зогсоож, эргэн төлөлт нь хуваарийн дагуу хийгдсэнээр банкуудад илүүдэл нөөц бий болж, төгрөгийн чөлөөт эх үүсвэрээ өгөөжтэй активт байршуулах, төлбөр түргэн гүйцэтгэх харьцаагаа хангах шаардлагын улмаас ТБҮЦ-д байршуулахад хүрсэн. Ингэснээр 2017 оны 11 дүгээр сараас хойш ТБҮЦ-ны хэмжээ өсч, дунджаар 4.5 орчим их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байлаа.

Монголбанк ТБҮЦ-ны хэмжээг хязгаарлах арга хэмжээ авах нь илүү том эрсдэлийг хуримтлуулах эрсдэлтэй тул хэмжээг хязгаарлах бус, харин хүүг нь эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй боломжит бага түвшинд байлгах бодлого баримталж байна. Банкны салбарт илүүдэл нөөц их хэмжээгээр бий болох үед ТБҮЦ-ыг хязгаарлах бодлого нь банкуудын гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлэх, валютын ханшийн сулрах дарамтыг нэмэгдүүлэх, банкууд ашигт ажиллагааг хангахын тулд ирээдүйд эрсдэл дагуулах, судалгаа муутай зээлийн хэт өндөр өсөлтийг бий болгохоор байв. Иймд санхүүгийн болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд ТБҮЦ-ны хэмжээг хязгаарлахгүй байх бодлого нь банкууд зохистой харьцааны үзүүлэлтээ хэвийн хангах, зээлийн өсөлт огцом бус алгуур байх, гадаад валютын нөөцийг ханшийн харьцангуй бага дарамттайгаар хуримтлуулах бололцоог олгож байна.

Нэгтгэн хэлэхэд, ЗГҮЦ-ны хэмжээ буурч, ТБҮЦ-ны хэмжээ нэмэгдсэн нь эдийн засагт сөрөг нөлөө бий болгоогүй бөгөөд төсвийн бодлогод зайлшгүй хийгдэх шаардлагатай тохируулга, гадаад валютын

нөөцийг нэмэгдүүлэх шаардлага болон эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг нэгэн зэрэг хангах хүрээнд бодлогын хувьд нийцтэй хэрэгжсэн хослол юм. Ялангуяа, ӨСХ-ийн хүрээнд Монгол Улсын хүлээж буй зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэхэд энэ сонголт зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Өнөөдрийн банкны салбарын чанаргүй зээл нь өмнөх эдийн засгийн хүндрэл, арга хэмжээний үр дагавар юм. Сүүлийн 2 жилд эдийн засаг сэргэж байгаа хэдий ч чанаргүй зээлийн ул суурь нь өмнө нь бий болж, ужгирсан тул дорвитой буурахгүй байна. Чанаргүй зээл 2019 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар 1.8 их наяд төгрөг буюу нийт зээлийн багцын 10.7 хувь, хугацаа хэтэрсэн зээл 0.9 их наяд төгрөг буюу нийт зээлийн 5.4 хувьтай тэнцэж байна. Банкны системд хуримтлагдаад буй чанаргүй зээл нь 2014 оноос гүнзгийрсэн эдийн засгийн хүндрэлийн дайвар бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл, 2012 оны сүүлээс дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ ханш унаж уул уурхайн салбар хүндэрсэн, барилгын салбарт борлогдохгүй орон сууц хурдацтай нэмэгдсэн зэргийн тусгал нь зээлийн эргэн төлөлт муудах хэлбэрээр банкны систем дээр илэрсэн явдал байв. 2019 оны 2 дугаар сарын байдлаар чанаргүй зээлийн хэмжээ уул уурхайн салбарт 470 тэрбум төгрөг, боловсруулах салбарт 376 тэрбум төгрөг, барилгын салбарт 287 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа нь нийлбэр дүнгээр банкны системийн чанаргүй зээлийн 60 гаруй хувийг дангаар бүрдүүлж байна (Хүснэгт 2).

Гэхдээ Монголын банкны системийн тогтвортой байдалд томоохон эрсдэл байхгүй байна. Тухайлбал, банкны системийн чанаргүй зээлийн 88 хувь нь зээлийн эрсдэлийн санг байгуулснаас гадна, банкны салбарын төлбөрийн чадвар өндөр, өөрийн хөрөнгө нэмэгдсэн тул салбарын эрсдэл даах чадвар дээшилж, санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэл бага байна. Ялангуяа, системийн хэмжээний банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 40 хувиас дээш буюу зохистой хэмжээ 25 хувиас эрс өндөр, өөрийн хөрөнгийн хүрэлцээний түвшин хангалттай байна. 2016 онтой харьцуулахад банкны систем илүү эрүүл, эрсдэл даах чадвар нь эрс дээшилсэн гэж дүгнэж болно. Чанаргүй зээл тодорхой түвшинд хүрэхээр хямрал тохиолдоно эсхүл тохиолдохгүй гэдэг зүй

тогтол үгүй бөгөөд тухайн цаг үед эдийн засагт бий болсон шокийн онцлог, системийн хэмжээний банкуудын тогтвортой байдал, санхүүгийн системд итгэх итгэл болон эрсдэл шилжиж системд тархах хурд зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална⁶. Манай орны хувьд банкны системийн тогтвортой байдал хадгалагдаж байна.

Хүснэгт 2. Чанаргүй зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбаруудаар /сая төгрөг/

	2019.02.28	%
Нийт чанаргүй зээл	1,838,323	100.0%
Уул уурхай, олборлолт	469,794	25.6%
Боловсруулах үйлдвэрлэл	376,142	20.5%
Барилга	287,466	15.6%
Бусад	172,329	9.4%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	149,900	8.2%
Бөөний болон жижиглэн худалдаа	135,190	7.4%
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	70,087	3.8%
Байр, сууц болон нийтийн хоолны үйл ажиллагаа	53,587	2.9%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	51,209	2.8%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	22,782	1.2%
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	21,015	1.1%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	8,173	0.4%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7,802	0.4%
Мэдээлэл холбоо	4,062	0.2%
Боловсрол	3,551	0.2%
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	2,667	0.1%
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1,448	0.1%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	1,119	0.1%

Эх сурвалж: Монголбанк

⁶ Олон улсын туршлагаар чанаргүй зээлийн хэмжээ 5 хувь дотор бага байх үед санхүүгийн хямрал тохиолдсон Америк (1984-91)-ийн жишээ бий бол 30% давж байж хямрал тохиолдсон Малайз (1985-88) болон Шри-Ланк (1989-93)-ийн жишээ бий. Эдийн засгийн хүндрэлийн үед системийн шинж чанартай зээл их хэмжээгээр, хурдтай чанаргүйдэх үзэгдэл ажиглагддаг. 1997 оны Азийн санхүүгийн хямралын үед гэхэд олон улс оронд чанаргүй актив 3 дахин нэмэгдэж байв. Жишээ нь, чанаргүй зээлийн ДНБ-д эзлэх хэмжээ Солонгост 14%, Индонезид 27%, Малайзд 32%, Тайландад 51% хүрч байв.

Зээл чанаргүйдэх үзэгдэл нь банкны бизнесийн салшгүй нэг хэсэг бөгөөд эдийн засаг хэвийн үед чанаргүй зээлийн хэмжээ бага байхаас гадна банк өөрөө шаардлагатай эрсдэлийн санг байгуулж, чанаргүй зээлийг эргэн төлүүлэх, тусгай активыг шийдвэрлэх тогтолцоогоороо дамжуулж шийдвэрлэдэг тул хурц асуудал үүсдэггүй. Үүнтэй харьцуулахад Монголын банкны системд 1.8 их наяд төгрөгтэй тэнцээд буй чанаргүй зээл нь ДНБ-ийн 5% орчим бөгөөд 88% нь шаардлагатай эрсдэлийн санг байгуулсан тул системийн хямрал үүсгэлгүй удирдаж болохоор хэмжээ юм.

Хэдийгээр банкны системд хуримтлагдаад буй чанаргүй зээл нь санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулахааргүй байгаа ч цаашид нэмэгдүүлэхгүй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, тогтолцоо Монгол Улсын хувьд чухал юм. Эдийн засгийн хүндрэлийн үед системийн хэмжээнд чанаргүй актив хурдтай нэмэгдэхээс сэргийлэх, нэгэнт үүссэн чанаргүй активыг санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулахгүйгээр шийдвэрлэхэд тодорхой бодлого стратеги, институцийн тогтолцоо, дэд бүтэц шаардагддаг. Хэрэв чанаргүй активыг шийдэхгүй орхивол санхүүгийн хүндрэлийг гүнзгийрүүлж, хугацааг уртасгах, улмаар макро эдийн засгийг удирдахад илүү хэцүү болгох эрсдэлтэй. Чанаргүй актив хэлбэрээр эдийн засагт их хэмжээний нөөц түгжигдэж, цааш дахин хуваарилалтад орохгүй болох нь санхүүгийн хүндрэлийг ч уртасгана. Үүнээс гадна чанаргүй актив нь эдийн засагт зуучлалын үүрэг гүйцэтгэгч санхүүгийн системийг эмзэг болгож улмаар эдийн засгийн үйл ажиллагаанд саатал учруулж, цаашид сэргэхэд хүндрэлтэй болгодог байна. Иймд Монголбанк банк санхүүгийн системд хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах чиглэлээр “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийг 2019 оны 6 дугаар сард СТБЗ-өөр батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улс уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос хамаарал өндөртэй, валютын захын арилжааны нийт эргэлт өндөр тул Монголбанк валютын ханшийн өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр анхааран ажилласаар ирэв. Энэ хүрээнд банкуудын гадаад зах зээлээс татсан эх үүсвэрийг

урт хугацаат своп хэлцлээр төгрөгт хөрвүүлэх, макро зохистой бодлогын арга хэрэгслээр дамжуулан банкуудын гадаад валютаар зээл олгох сонирхлыг бууруулах арга хэмжээ авч ирлээ. Үүний үр дүнд 2013 онд 1.8 тэрбум ам.доллартай тэнцэж байсан гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ 2019 оны 2 дугаар сарын байдлаар 1.0 тэрбум ам.доллар болж 80 хувиар буураад байна. Түүнчлэн нийт зээлд эзлэх гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ 2019 оны 2 дугаар сарын байдлаар 15% болж 2013 оны эцсээс 12 нэгж хувиар буураад байна (Зураг 14). Энэ нь ханшийн өөрчлөлтийн валютын зээлийн эргэн төлөлтөд үзүүлэх сөрөг нөлөөг энэ хэмжээгээр бууруулсантай утга нэг юм.

Зураг 14. Гадаад валютаар олгосон зээл



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны хуримтлагдсан 3 их наяд төгрөгийн алдагдлыг 1.2 их наяд төгрөгөөр бууруулж, цаашид ашигтай болгох зорилт тавин ажиллаж байна. Монголбанк 2012-2016 онуудад алдагдалтай ажиллаж хуримтлагдсан алдагдал 3 их наяд төгрөг хүрээд байв. Эдгээр он жилүүдэд Монголбанк төсвийн шинж чанартай үйл ажиллагаа эрхэлж, гадаад валютын өрийг нэмэгдүүлсэн нь дээрх том хэмжээний алдагдалтай ажиллахад хүргэсэн байв.

Харин сүүлийн 2 жил гаруй хугацаанд Монголбанк улс орныг гадаад валютын өрөнд оруулсан, санхүүгийн тэнцэлд сөргөөр нөлөөлөхүйц өнгөрсөн он жилүүдийн бодлогын алдааг давтахгүй байх зарчмыг баримтлан ажиллаж ирлээ. Харин гадаад захын тогтвортой байдлыг хангах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд санхүүгийн

хэрэгслүүдийг шаардлагатай тухай бүр зах зээлийн нөхцөлөөр гэрээ байгуулан, ашиглаж байна.

Монголбанкны гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, алдагдалтай санхүүгийн хэлцэл хийхгүй, санхүүгийн сахилга батыг хангаж ажилласны үр дүнд 2017, 2018 орнуудад ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгө -3 их наяд төгрөг байсныг 1.2 их наяд төгрөгөөр бууруулж, 1.8 их наяд төгрөг болгоод байна. Бидний тооцоогоор одоо баримталж буй зарчим, үйл ажиллагаагаа цаашид хадгалан ажиллавал Монголбанк 2019 болон 2020 онд үргэлжлүүлэн ашигтай ажиллах бөгөөд өөрийн хөрөнгийг эерэг болгох зорилтын төлөө ажиллаж байна.

Монголбанкны дотоод үйл ажиллагаанд шинэчлэлт хийж, олон улсын төв банкны жишигт хүргэхээр ажиллаж байна. Монголбанк 2018 оноос нягтлан бодох бүртгэлийн олон улсын IX стандартын дагуу санхүүгийнхээ тайланг гаргаж, Төв банкны тайлагналын найдвартай, хариуцлагатай байдлыг бататгалаа. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн эд зүйлст анх удаа олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэж, сан хөмрөгөө түүхийн хосгүй үнэт олдворуудаар баяжууллаа. Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг бүрдүүлж, банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дээд хязгаарыг 3 сая төгрөг болгон нэмэгдүүлж, гүйлгээ дамжуулах хурдыг 3 дахин өсгөж, системийн тасралтгүй, найдвартай байдлыг бэхжүүлээ. Үүний зэрэгцээ төгрөгтэй адилтгах бэлэн бус төлбөрийн хэрэгсэлд анхны тусгай зөвшөөрлийг олгож, Финтекийн цаашдын хөгжлийг дэмжих суурийг тавилаа.

Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн шинэчилж, чадварлаг залуу удирдлагын багийг бүрдүүлэн хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгон ажиллаа. Үүний зэрэгцээ Монголбанкны ажилчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлд анхааран ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд хаягдаад байсан Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааг сэргээж, "Монгол Улсын эрдэнэсийн сан" ном гаргаж, хосгүй үнэт эрдэнэсийн сангийн үзвэрээс бүрдсэн музей болгон тохижуулж нийтэд нээлттэй болголоо.

Сүүлийн үеийн технологийн дэвшлийг Монгол Улсын төлбөрийн систем, ₮ картын шинэчлэл, мөнгөн дэвсгэртийн шинэчлэл, дурсгалын зоосны үйлдвэрлэл, нууцлалыг сайжруулах зэрэгт өргөн нэвтрүүлж байна. Дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд идэвхтэй ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын гишүүнчлэлтэй олон улсын санхүүгийн байгууллагуудын дээд удирдлагуудтай байнга уулзаж, өөрийн орны нөхцөл байдлыг тайлбарлан таниулж, цаашдын хамтын ажиллагаа, тусламж дэмжлэгийн талаар ярилцаж байна. Төв банкуудын төв банк гэгддэг Олон улсын төлбөр тооцооны банкинд Монголбанкийг гишүүнчлэлээр элсүүлэх боломжийг судалж, холбогдох уулзалтуудыг хийж байна. Үүний зэрэгцээ Монголбанкны захиалгаар мөнгөн дэвсгэрт, зоос үйлдвэрлэдэг болон үнэт металл цэвэршүүлдэг компаниудтай нягт хамтран, туршлага судлан ажиллаж байна.

Монголбанкны судалгаа, шинжилгээний ажилд өндөр ач холбогдол өгч, шилдэг ТинкТанк гэсэн байр сууриа бэхжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд улс орны хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлох том институци болгох алсын хараатайгаар Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнг Монголбанкны дэргэд шинээр байгуулан ажиллуулж байна. Монголбанкны бодлого, судалгааны ажлуудыг бодлого боловсруулагчид салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид болон олон нийтэд хүргэж, тэдгээрийн санал, шүүмжийг авч тусгах зорилгоор мэргэжлийн болон нийтийн хэлэлцүүлэг, хурлыг богино давтамжтайгаар зохион байгуулж байна. Түүнчлэн "Монголбанкны мэдээлэл", "Мөнгө, Санхүү, Баялаг" сэтгүүл, бусад судалгаа, шинжилгээний сэдэвчилсэн товхимол, ном зэргийг шинээр санаачлан гаргаж, нийтийн хүртээл болголоо.

Дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран харилцан санал солилцох уулзалт хийх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийлгэх, хурал, хэлэлцүүлэг болон аян зохион байгуулах зэрэг олон чиглэлээр нягт хамтран ажиллаж байна. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх болон Монгол Улсын Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагаа,

энэ чиглэлд холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахад онцгой анхаарч, дэмжлэг үзүүлэн ажиллаж ирлээ.

Эдийн засгийн цаашдын төлөв байдлыг авч үзвэл, эдийн засгийн сэргэлт үргэлжилж, өсөлт 2018 оны түвшнээс буурахгүй байх, инфляци зорилтот түвшний орчим байхаар хүлээгдэж байна. Гэхдээ эдийн засагт томоохон сорилтууд тулгарсан хэвээр байна. Ойрын 4-5 жилийн хугацаанд төлөгдөх өр болон хувийн хэвшлийн томоохон дүнтэй гадаад өр, төлбөрийг барагдуулахад нийт 13.3 тэрбум ам.доллар шаардагдах урьдчилсан тооцоо гарч байна. Иймд эрсдэлийг даван туулах бэлтгэлийг хангах үүднээс олон ажлыг цаг алдалгүй хийх шаардлагатай байна. Тухайлбал, гадаад валютын нөөцийг цаашид нэмэгдүүлэх, тогтвортой өсөлтөд чиглэсэн харилцан хосолсон макро бодлогыг хэрэгжүүлэх, макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс төсвийн сахилга батыг чандлан сахих, эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох, банк, санхүүгийн салбарын эрүүл мэнд, эрсдэл даах чадварыг сайжруулах, банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, гадны хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих, томоохон төсөл хөтөлбөрүүдийг тогтвортой хэрэгжүүлэх, уул уурхайгаас бусад экспортын чиг баримжаатай салбаруудыг дэмжих, гадаад худалдааг хөнгөвчлөх, дэмжих цогц бодлого хэрэгжүүлэх, гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, оновчтой бүтцийг бий болгох шаардлага өндөр хэвээр байна.

Цаашид Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь манай эдийн засгийн хэтийн төлөвт стратегийн чухал ач холбогдолтой юм. Тэр дундаа, Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлыг дунд хугацаанд үргэлжлүүлэн хангахад ОУВС болон бусад доноруудын тусламж дэмжлэг цаашид ч онцгой шаардлагатай байгааг энд онцлох нь зүйтэй.

Монгол Улсын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, эдийн засгийн өсөлтийг нийт ард иргэд, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгох зорилгоор Монголбанкнаас авч буй арга хэмжээ, хүрсэн нааштай үр дүнг зориудаар мушгин гуйвуулж, олон нийтэд буруу ташаа мэдээлэл тарааж, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад тотгор үүсгэж байгаад бид туйлаас харамсаж байна. Үүссэн нөхцөл байдал нь Монголбанкны үйл ажиллагаанд саад болж байгаа хэдий ч бидний зүгээс үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлж байгаагаа мэдэгдэж байна.

Олон ажлыг хийж амжууллаа, цаашид хийх ажил их байна.

Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг улам бэхжиж, Эрдэнэсийн сан цаашид улам өргөжин баяжих болтугай!

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАЯРТСАЙХАН

2019 оны 4 сарын 22



 www.mongolbank.mn

 [Mongolbank.mn](https://www.facebook.com/Mongolbank.mn)

 [@mongolbank_mn](https://twitter.com/mongolbank_mn)

 Бага тойруу-3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс